

**БИЧИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ
АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй...” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 3.2.1.1-д “Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно” гэж, 3.2.1.5-д “Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх ур чадварыг хөгжүүлэх, бичил, жижиг, дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тогтвортой ажлын байр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжих, бичил, жижиг, дунд бизнесийн урт хугацаатай, хүү багатай санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бизнес инкубацийн үйлчилгээг хөгжүүлэх, гарааны бизнесийг дэмжих, санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, татварын орчныг боловсронгуй болгох, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд таатай санхүүгийн орчин бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.2-т “Хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх” гэж, 7.1-д

“Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг сайжруулах” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2025 оны 14 дүгээр тогтоолоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах чиглэлийг Засгийн газарт өгсөн нь бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эрх зүйн орчныг шинэ шатанд боловсронгуй болгох бодлогын шаардлагыг илэрхийлж байна.

Иймд иргэн, өрхийн бизнес эрхлэгч, иргэдийн бүлгийн түвшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчин одоогийн хууль тогтоомжид бие даасан байдлаар бүрэн зохицуулагдаагүй, төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, санхүүгийн хүртээмж, бизнес хөгжлийн үйлчилгээ, зах зээлийн дэмжлэг, нийгмийн хамгааллын зохицуулалт хангалтгүй байгаа тул бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн бодлого, дэмжлэгийн тогтолцоог оновчтой тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг өсгөх, орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулсан болно.

1.2. Практик шаардлага

Дэлхийн эдийн засагт, тэр дундаа хөгжиж буй орнуудын хувьд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид нь эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого, ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн нийт бизнесийн 90 орчим хувь, ажлын байрны 50 гаруй хувийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид бүрдүүлдэг бөгөөд хөгжиж буй орнуудын үндэсний орлогын 40 орчим хувийг албан ёсны бүртгэлтэй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид бий болгодог байна. Албан бус салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, өрхийн болон бичил бизнесийг нэмж тооцвол энэ үзүүлэлт улам нэмэгдэх хандлагатай байна.

Дэлхийн Банкны тооцооллоор 2030 он гэхэд өсөн нэмэгдэж буй ажиллах хүчийг шингээхэд 600 сая орчим шинэ ажлын байр шаардлагатай болох бөгөөд үүнийг хангах гол суурь нь бичил, жижиг, дунд бизнесийн хөгжил гэж үзэж байна. Иймд олон улсын түвшинд бичил бизнесийг зөвхөн жижиг, дунд үйлдвэрийн доод ангилал бус, харин өөртөө ажлын байр бий болгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх, жижиг, дунд бизнес болон шатлан хөгжих суурь хэлбэр гэж үзэн тусгайлан дэмжих бодлого хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд 2024 оны байдлаар бүртгэлтэй 261,157 аж ахуйн нэгжээс 108,378 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 76.2 хувь буюу 82,562 нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан ангиллын дагуу бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж 54,239, жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж 23,562, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж 4,761 байна. Мөн нийт хөдөлмөр эрхлэлтийн 40.1 хувь буюу 549,791 иргэн жижиг, дунд үйлдвэрийн салбарт ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд жилийн 300 саяас 1 тэрбум хүртэлх төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10-50 хүнийг ажлын байраар хангадаг бизнесийг **“жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”**, харин 300 сая хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй 10 хүртэлх хүнийг ажлын байраар хангадаг бол **“бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”** гэж тодорхойлдог.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн 59 хувь буюу дийлэнх нь жилийн 50 хүртэлх сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулдаг бичил бизнес эрхлэгчид байна. 2020 оны байдлаар нийт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн 84,51 %, 2021 онд 80,99 хувийг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид эзэлсэн байна¹.

Эдгээр тоон үзүүлэлтээс харахад жижиг, дунд үйлдвэрийн салбарын дийлэнх хэсгийг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байгаа боловч одоогийн эрх зүйн зохицуулалт нь бичил бизнесийн онцлог, хэрэгцээ шаардлагыг бүрэн тусгаж чадахгүй байна. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд “бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”-ийг үндсэндээ аж ахуйн нэгжийн хэлбэрээр тодорхойлсон нь заавал хуулийн этгээд байгуулаагүй боловч үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн, өрхийн бизнес эрхлэгч, иргэдийн бүлгийг төрийн дэмжлэгийн гадна үлдээх нөхцөлийг бий болгож байна.

Хэдийгээр бичил бизнес эрхлэгчид нь бусад томоохон аж ахуй нэгж байгууллагуудтай харьцуулахад татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт бага хэдий ч өөртөө ажлын байр бий болгох, орлого олох боломжийг бүрдүүлж жижиг, дунд бизнес болон өргөжихийн хэрээр ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлдөг тул тэднийг дэмжих эрх зүйн орчныг илүү тодорхой болгож бодитоор дэмжих шаардлагатай байна.

Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өмнө тулгамдаж буй гол хүндрэл нь санхүүжилтийн хүртээмж, барьцаа хөрөнгийн шаардлага, бизнесийн мэдлэг мэдээллийн дутагдал, татвар болон нийгмийн даатгалын ачаалал, тоног төхөөрөмж, түүхий эдийн өртөг, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын суваг хязгаарлагдмал байдал юм. Ялангуяа бизнесээ эхлүүлж буй иргэн, өрхийн бизнес эрхлэгч, иргэдийн бүлэг нь үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээс зээлд хамрагдах боломжгүй, арилжааны банкны хэрэглээний зээлээр бизнесээ санхүүжүүлэх, эсхүл үйл ажиллагаагаа албан бус хэлбэрээр үргэлжлүүлэх нөхцөл байдал түгээмэл байна.

Түүнчлэн бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн худалдан авалтад оролцуулах, орон нутгийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, томоохон төсөл, хөтөлбөр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоодын бичил бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх

¹ Монгол Улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээлэл, 4 дэх тал

эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

Одоогийн байдлаар жижиг, дунд үйлдвэрийн асуудал төрийн захиргааны байгууллагын түвшинд зохицуулагдаж байгаа боловч бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид рүү чиглэсэн тусгайлсан бүртгэл, мэдээллийн сан, санхүүгийн дэмжлэг, бизнес хөгжлийн үйлчилгээ, сургалт, зөвлөгөө, борлуулалтын дэмжлэг, хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээний нэгдсэн тогтолцоо хангалттай төлөвшөөгүй байна. Аймаг, орон нутагт жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан хүний нөөц хязгаарлагдмал, орон нутгийн бизнес инкубатор, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвүүдийн үйл ажиллагаа нэгдсэн бодлого, арга зүй, удирдлага зохицуулалтгүй явж ирсэн нь бичил бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн хүртээмжийг бууруулж байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын ирүүлсэн мэдээллээр 2020-2024 онд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс нийт 520,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3865 төслийн санал ирүүлснээс 24,8% буюу 960 төсөлд л зээл олгожээ. 2018-2020 оны байдлаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зээлийн санхүүжилт, төслийн тоог харгалзаж үзвэл 2018 оны байдлаар 212 төсөлд 96.3 тэрбум төгрөгийн, 2019 оны байдлаар 451 төсөлд 47.4 тэрбум төгрөгийн, 2020 оны байдлаар 249 төсөлд 22.8 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгожээ. Энэ нь нэг төсөлд ногдох дундаж зээлийн хэмжээ 90-100 сая төгрөг болох нь харагдаж байгаа бөгөөд дээр дурдсан нийт ЖДҮ эрхлэгчдийн 50 орчим хувийг эзлээд байгаа бичил бизнес эрхлэгчдэд төрөөс үзүүлж байгаа зорилтот зээлийн санхүүжилт, дэмжлэг хүртээмжгүй байгаа нь харагдаж байна.

УИХ-ын Тамгын газрын Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт 2025 оны 09 сард үнэлгээ хийсэн ба уг тайланд төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэлд тусгагдсан зах зээлийн эрэлт, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоо бүрэн хөгжөөгүй, зээл зорилтод бүлгийг бүрэн хамруулж чадаагүй, зээлийн хүүгийн хэмжээг бууруулах болон, зээлийн хүүгийн татаас олгох зэрэг дэмжлэгүүд огт хэрэгжээгүй, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар мэдээллийн хүртээмж султай холбоотойгоор 2024 онд нийт ЖДҮҮЭ-ийн 13% нь л энэ төрлийн хөнгөлөлт эзэлсэн, төрийн худалдан авалтаар бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд зохион байгуулсан 3 удаагийн арга хэмжээнд нийт ЖДҮҮЭ-ийн дөнгөж 0,8 хувь нь оролцсон, тус хуулийн 9 дүгээр зүйлд жижиг, дунд үйлдвэрийг кластераар дэмжинэ гэсэн боловч 2019 оноос хойш өдрийг хүртэл “Кластераар бүсчилэн хөгжүүлэх чиглэл”, “Кластерийн ангилал тооцох журам” зэрэг шаардлагатай баримт бичгүүд батлагдаагүй байна гэжээ.

Түүнчлэн Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг чөлөөлөх, бизнес эрхлэх орчныг хялбаршуулах бодлогын хүрээнд иргэн, өрхийн бизнес эрхлэгч, иргэдийн бүлгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна. Тухайлбал, зөвшөөрөл шаардахгүй үйл ажиллагаанд

дүгнэлт, гэрээ, тодорхойлолт, бүртгэл зэрэг нэрээр нэмэлт баримт бичиг шаардах, бизнес эхлүүлэх хугацааг удаашруулах, иргэдэд хүнд суртал үүсгэх явдал бичил бизнес эрхлэгчдэд хамгийн их дарамт болж байна.

Иймд “мэдэгдээд шууд эхлэх” зарчмыг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хэрэгжүүлэх, зөвшөөрөлгүй эрхлэх боломжтой үйлдвэрлэл, үйлчилгээний төрлийг тодорхой болгох, төрийн байгууллагаас шаардах баримт бичиг, шат дамжлагыг багасгах, бүртгэл, мэдээлэл, дэмжлэгийг цахим хэлбэрээр нэг цонхоор үзүүлэх, төрөөс тавих хяналтыг бизнес эхлүүлэхээс өмнөх зөвшөөрөлд бус эрсдэлд суурилсан дараах хяналтын хэлбэрт шилжүүлэх шаардлагатай байна.

Энэ нь хөдөлмөрлөж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг төрийн хүнд суртлаас чөлөөлөх, бичил бизнесийг албан эдийн засагт оруулах, өрхийн орлого болон орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлэх, төрийн дэмжлэгийг бодит эзэнд нь хүргэх практик ач холбогдолтой юм.

Иймд бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг зөвхөн аж ахуйн нэгжийн хүрээнд бус, иргэн, өрхийн бизнес эрхлэгч, иргэдийн бүлгийн түвшинд тодорхойлж, тэдгээрийг бүртгэх, ангилах, төрийн дэмжлэгт хамруулах, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх, сургалт, зөвлөгөө, мэдээллээр хангах, борлуулалт, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, татвар, нийгмийн даатгалын бодлогын дэмжлэг үзүүлэх, бичил бизнесийг жижиг, дунд үйлдвэрлэл болон шатлан хөгжүүлэх эрх зүйн үндсийг засгийн газрын эдийн засгийг чөлөөлөх бодлоготой уялдуулан бие даасан хуулиар зохицуулах практик шаардлага бий болсон байна.

Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих суурь хуулийн зохицуулалтаас олон бизнес эрхлэгчид орхигдож буй нөхцөл байдал бий болоод байгаа тул бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч гэдэг нэр томъёонд хамаарагдах субъектийн хүрээг тэлэхийн зэрэгцээ зах зээлийн нөхцөл байдал, нийт ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын орлогын хэмжээг харгалзан бодит нөхцөл байдалд тулгуурлан бичил бизнес эрхлэгч ААНБ-тай холбогдох харилцааг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн үйлчлэлд хэвээр үлдээж, ААНБ-ын зохион байгуулалтад ороогүй бусад иргэн, иргэдийн бүлэг, өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжих, тэднийг БИЧИЛ-ээс ЖИЖИГ үйлдвэр үйлчилгээ эрхлэгч болгон бойжуулах эрх зүйн үндэсийг бие даасан тусдаа хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагын дагуу “Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг дэмжих тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулав.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн зорилго нь дотоодын бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, өрсөлдөх чадварыг сайжруулах, өөртөө болон бусдад ажлын байр бий болгох боломжийг өргөжүүлэх, өрхийн бизнесийн эдийн засагт эзлэх хувь оролцоог

дээшлүүлэх, бичил үйлдвэрлэл, үйлчилгээг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний түвшинд хүргэхэд чиглэх бөгөөд

Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих суурь хуулийн зохицуулалтаас олон бизнес эрхлэгчид орхигдож буй нөхцөл байдал бий болоод байгаа тул бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч гэдэг нэр томъёонд хамаарагдах субъектийн хүрээг тэлэхийн зэрэгцээ зах зээлийн нөхцөл байдал, нийт ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын орлогын хэмжээг харгалзан бодит нөхцөл байдалд тулгуурлан бичил бизнес эрхлэгч ААНБ-тай холбогдох харилцааг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн үйлчлэлд хэвээр үлдээж, ААНБ-ын зохион байгуулалтад ороогүй бусад иргэн, иргэдийн бүлэг, өрхийн бизнес эрхлэгчидтэй холбоотой харилцааг зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгана. Үүнд:

- Хуулийн зорилго, зорилт, нэр томъёонд бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг 150.0 сая хүртэл төгрөгийн борлуултын орлоготой, иргэн, иргэдийн бүлэг, өрхийн бизнес эрхлэгч хэмээн тодорхойлно.

- Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн бүртгэлтэй холбоотой болон хамаарахгүй этгээдийг нарийвчлан зааг ялгааг тодорхой болгосноор зээл, дэмжлэг эзнээ олох боломж нэмэгдэнэ..

- Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих төрийн бодлого, дэмжлэгийн хэлбэр, кластерийн үйл ажиллагаа, цахим мэдээллийн сангийн талаарх зүйл, заалтыг тусгана.

- Санхүүгийн хүртээмжийг сайжруулах зорилгоор ЖДҮ сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй зээлийг жилд нэг л удаа сонгон шалгаруулдаг байдлыг халж, тасралтгүй шатлан олгох, хөнгөлөлттэй зээлийн нөхцөл, хуваарилалтыг тодорхой болгох,

- Бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд хөгжлийн үе шатанд тохирсон татвар, нийгмийн даатгалын ялгамжтай орчныг бүрдүүлэх

- Нөхөн сэргээгддэггүй газрын хэвлийн баялгийн орлогоос нөхөн сэргээгддэг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх;

- Мэдээллийн хүртээмж, сургалт, зөвлөх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг сайжруулах;

- Өөртөө ажлын байр бий болгож буй өрхийн бизнес эрхлэгч болон гарааны бизнес эрхлэгч иргэн, иргэдийн бүлгийг дэмжих, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, олон хүүхэдтэй өрх толгойлсон, эх эцэг бичил бизнес эрхлэгч бол бизнес эрхлэх илүү таатай орчныг бүрдүүлэх ;

- Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч орон нутгийн иргэдийг нэн тэргүүнд дэмжих, чанар, стандартын шаардлага хангасан бичил бизнес эрхлэгч ИРГЭНИЙ бараа, ажил, үйлчилгээг төрийн худалдан авалтаар дэмжих;

- Бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих дэд бүтцийг шийдвэрлэх, техник, тоног төхөөрөмжөөр хангах, төрийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглагдахгүй байгаа, төрийн байгууллагууд шинэ байранд шилжих үед суларсан барилгыг бичил, жижиг,

дунд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашиглуулах, газар эзэмшүүлэх, ашиглуулах, цахимжуулалтыг дэмжих;

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Бичил, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай анхдагч хуулийн төслөөр шинэ сан, шинэ төрийн байгууллага байгуулахгүй бөгөөд хэрэгжилтийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон хүчин төгөлдөр хууль тогтоомжид заасан санхүүжилтийн эх үүсвэрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг жил бүрийн улсын төсөв батлахдаа холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх ба урт хугацаад нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна.

Үүнд:

1/ Төрөөс үзүүлж буй дэмжлэг, үйлчилгээ, хамтран ажиллах боломж, нөхцөл бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд илүү оновчтойгоор хүрэх болно.

2/Улмаар бичил бизнесээс жижиг бизнес рүү, жижиг бизнесээс дунд бизнес рүү, дунд бизнесээс томоохон үйлдвэр эрхлэлт рүү шат дараатай шилжих замаар бичил бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, үйл ажиллагаагаа өргөтгөх идэвх, санаачилга нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдэх нөхцөл бий болно.

3/Эдгээрийн үр дүнд эдийн засагт эерэг үр дагавар бий болж байгаль орчинд халгүй өндөр болон дэвшилтэд технологи нэвтэрч, нэмэгдсэн өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжих ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн боловсруулах болно. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн татвараас чөлөөлөх тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ